

ЛГБТИ эрх ба тэгш байдлын төлөөх эвсэл Монголд байгуулагдлаа



Улаанбаатар (2018 оны 8-р сарын 3)
– Нэгдсэн Үндэстний Байгууллагын Монгол дахь Суурин зохицуулагчийн газар ЛГБТ Төвтэй хамтран Тэгш эрхийн төлөөх эвслийг байгууллаа.

Тус Эвсэл нь Монголын ЛГБТИ хүй олны хүний эрхийг хөхиүлэн дэмжих, ЛГБТИ эрхийн төлөө нөлөөллийн ажил хийх, “Тэгш эрх, бахархлын өдрүүд”-ийг тэмдэглэхэд иргэний нийгэм, олон улсын байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, төрийн байгууллагууд болон хувийн салбарыг нэгтгэх зорилготой.

НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч хатагтай Биате Транкманн “Монгол Улсад ЛГБТИ хүн байх амаргүй. ЛГБТИ хүмүүсийн талаарх үнэн зөв мэдээлэл нийгэмд маш дутмаг байгаа учир нөхцөл байдлыг сайжруулахын тулд томоохон нөлөөллийн ажлууд шаардлагатай байна. Энэхүү эвсэл нь нийгэмд ойлголт өгөх, ЛГБТИ эрхийн асуудлаар хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал алхам болно” гэлээ.

НҮБ-ын үзэж байгаагаар Монгол дахь ЛГБТИ хүмүүсийн эрх зүй, бодлогын орчин сайжирсан хэдий ч ЛГБТИ хүмүүс эрхээ бүрэн эдлэх боломжгүй байсаар байна. ЛГБТИ хүмүүсийн эрх зүйн хамгаалалт, хөдөлмөр эрхлэлт, хэвлэл мэдээллээр дүрслэгдэж буй байдал, эрүүл мэндийн асуудал нь сэтгэл зовним хэвээр байна.

Гэсэн хэдий ч ЛГБТИ хүй олны өмнө тулгарч буй асуудал зөвхөн Монголын асуудал биш юм. АНУ-ын саяхны судалгаагаар гей, лесбиян өсвөр үеийнхэн бусад өсвөр үеийнхэнтэй харьцуулахад 4 дахин илүү, трансжендэр өсвөр үеийнхэн 10 дахин илүү амиа егүүтгэх оролдлого хийдгийг олж тогтоосон. Өнгөрсөн жил Дэлхийн банкны хийсэн анхдагч судалгаагаар Энэтхэг Улсад ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхах нь тус улсын эдийн засагт жил бүр 32 тэрбум ам.долларын алдагдлыг үүсгэж байгааг тогтоосон.

Томоохон сорилтууд шийдэгдээгүй хэвээр байгаа хэдий ч Монгол Улс тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлж байна. 2015 онд батлагдсан шинэ Эрүүгийн хууль 2017 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба тус хуульд бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаагаар ялгаварлан гадуурхахыг гэмт хэрэгт тооцдог болсон. Мөн УИХ-ын намрын чуулганаар дахин хэлэлцэгдэх Хөдөлмөрийн тухай шинэ хуульд ч бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээр ялгаварлан гадуурхахыг хориглосон.

“Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийллээс үл хамааран хүн бүрийг эн тэнцүү хамгаалах, тэгш эрхийг нь хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын авч хэрэгжүүлж буй бахархуштай арга хэмжээгээ үргэлжлүүлэхийг уриалахын сацуу хойш тавилгүй бүх цөөнхүүдийн тэгш эрхийг бодит байдал болгох ялгаварлан

гадуурхалтын эсрэг бие даасан, цогц хууль тогтоомж боловсруулах ажлаа эхлүүлэхийг уриалж байна. Монгол Улс энэ үүргийг олон улсын нийгэмлэгийн өмнө хүлээсэн ба олон улсын нийгэмлэг энэхүү хэрэгжилтийг хүлээсээр байна, ЛГБТИ болон бусад бүх цөөнх хүй олон нийт үүнийг шаардаж байна” хэмээн ЛГБТ Төвийн зөвлөх Н. Анараа хэллээ.

2018 оны 8-р сарын 25-нд ЛГБТ Төв 6 дахь жилдээ “Тэгш эрх, бахархлын өдрүүд”-ийг зохион байгуулахаар бэлтгэж байна. Бахархлын өдрүүдээр НҮБ, түнш байгууллагуудын хамтаар ЛГБТИ хүмүүсийн тэгш эрх, нийгмийн шударга хандлагыг дэмжих зорилготой НҮБ-ын олон нийтийн мэдээллийн “Тэгш ба Чөлөөт” кампанит ажлын нээлтийг хийх юм. Тус арга хэмжээ нь хүн бүрт нээлттэй бөгөөд олон нийт, хүн болгоныг тэгш эрх, шударга ёсны төлөө нэгдэхийг уриалж байна.

###

“Тэгш ба Чөлөөт” кампанит ажил нь НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газрын санаачилга ба нийгмийн сүлжээнд тулгуурласан хүний эрхийн асуудлаарх дэлхийн кампанит ажлуудаараа тэргүүлэгч Purpose сантай түншлэн хэрэгжүүлдэг.

"ЛГБТ Төв" ТББ нь ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй, төрийн бус байгууллага юм. "ЛГБТ Төв" ТББ-ын эрхэм зорилго нь Монгол Усын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Монгол Улсын олон улсын гэрээ, конвенциор баталгаажсан хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, аливаа алагчлалаас ангид байх ардчилсан иргэний нийгмийн үнэт зүйлийг Монголын нийгэмд төлөвшүүлэх, ийнхүү төлөвшүүлснээр бэлгийн цөөнх болох ЛГБТИ хүмүүсийн эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хүний эрхийн зөрчлийг бууруулах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд хувь нэмрээ оруулах, байгууллагын эрхэм зорилгод хүрэхийн тулд ижил төстэй зорилго бүхий олон улсын болон дотоодын төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын засгийн газар хоорондын байгууллагуудтай хамтран ажиллахад оршино.